



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 5 сарын 04 өдөр

Дугаар 169

Улаанбаатар хот

Нийтэд санал болгон гаргаж буй
үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол Базальт” Хаалттай ХК нь нээлттэй хувьцаат компани болон өөрчлөн зохион байгуулагдсантай холбогдуулан тус компанийн нэг бүр нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 56,417,000 /тавин зургаан сая дөрвөн зуун арван долоо мянга/ ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/, төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТХТ” ХХК /Ш.Лхагва/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. “Монгол Базальт” Хаалттай ХК-ийн нэг бүр нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 39,491,900 /гучин есөн сая дөрвөн зуун ерөн нэгэн мянга есөн зуу/ ширхэг хувьцааны өмчлөх эрхийг энэхүү тогтоолын хавсралтад заасан хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд баталгаажуулан бүртгэхийг “ҮЦТХТ” ХХК /Ш.Лхагва/-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоолын 1-д заасан хувьцаанаас 16,925,100 /арван зургаан сая есөн зуун хорин таван мянга нэг зуу/ ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар тус бүрийн үнийг 380 /гурван зуун ная/ төгрөгөөр нийтэд санал болгон худалдахыг “Монгол Базальт” Хаалттай ХК /Л.Ариунболд/-д зөвшөөрсүгэй.

4. Нийтэд санал болгон худалдаалах хувьцааг 100 /нэг зуу/ хувь зах зээлд арилжаалсан тохиолдолд үнэт цаасыг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагаа амжилттай болсонд тооцохыг “Монгол Базальт” Хаалттай ХК /Л.Ариунболд/-д мэдэгдсүгэй.

5. Хорооноос анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцох хүртэлх хугацаанд үнэт цаасны арилжаанаас татан төвлөрүүлэх хөрөнгийг тусгаарлахыг “Арилжааны төлбөр тооцоо” ХХК /О.Эрдэнэгэрэл/-д үүрэг болгосугай.

6. Энэ тогтоолын хавсралтад заасан хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд буй хувьцааг 6 сарын хугацаанд тусгаарлахыг “ҮЦТХТ” ХХК /Ш.Лхагва/-д үүрэг болгосугай.

7. Энэ тогтоолын 4-т заасан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд “Бумбат Алтай ҮЦК” ХХК /Ш.Энхмэнд/, “Гаүли ҮЦК” ХХК /Хан Гю Бун/, “Стандарт Инвестмент ҮЦК”

/Ч.Жаргал/-д хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг тус тус мэдэгдсүгэй.

8. “Монгол Базальт” Хаалттай ХК нь компани нь нээлттэй хувьцаат компани болж байгаатай холбогдуулан компанийн шинэчилсэн дүрмийг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Монгол Базальт” Хаалттай ХК /Л.Ариунболд/-д үүрэг болгосугай.

9. Үнэт цаасны танилцуулга холбогдох баримт бичгийг бэлтгэхэд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, зөрүүтэй, алдаатай мэдээлэл тусгасны улмаас хөрөнгө оруулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Бумбат Алтай ҮЦК” ХХК /Ш.Энхмэнд/, “Өмгөөллийн фاینэншил лоо консалтинг” ХХН /С.Батхүлэг/, “Бест Фортуна Аудит” ХХК /Ж.Оюунцэцэг/, “Мөнх оргил трейд” ХХК /Б.Эрдэнэбаатар/-д тус тус анхааруулсугай.

10. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2018 оны 5. дугаар сарын 04-ний
өдрийн 19 дүгээр тогтоолын хавсралт



Д/д	Хувьцаа эзэмшигчдийн нэрс	“Монгол Базальт” Хаалттай ХК-д эзэмших хувьцаа	“Монгол Базальт” Хаалттай ХК-ийн эзэмших хувь
1.	Лхагважавын Ариунболд	20,140,869	35.7%
2.	Пүрэвбанзрагчийн Сайнбилэг	7,503,461	13.3%
3.	Ариунболдын Энхгэрэл	3,949,190	7.0%
4.	Ариунболдын Энхмаа	3,949,190	7.0%
5.	Ариунболдын Энхжин	3,949,190	7.0%
	Нийт дүн	39,491,900	70%